



**ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ**

2023 оны 09 сарын 13 өдөр

Дугаар 109

Улаанбаатар хот

Тусгай зөвшөөрлийн хугацаа сунгах тухай

Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.5 дугаар зүйлийн 10 дахь хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.10 дахь заалт, Радио долгионы тухай хуулийн 5¹ дүгээр зүйлийн 5¹.1.8 дахь заалт, Шуудангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Энэхүү тогтоолын хавсралтын 1-т заасан хуулийн этгээдийн “Харилцаа холбооны сүлжээ байгуулах, түүний ашиглалт үйлчилгээ эрхлэх /Шуудангийн сүлжээ байгуулах/” болон “Дотоодын шуудангийн үйлчилгээ эрхлэх” тусгай зөвшөөрлийг 5 жилийн хугацаагаар, 2-т заасан хуулийн этгээдийн “Өргөн нэвтрүүлгийн телевизийн үйлчилгээ эрхлэх” тусгай зөвшөөрлийг 5 жилийн хугацаагаар, 3-т заасан хуулийн этгээдийн “Арилжааны радиогийн үйлчилгээ эрхлэх” болон “Радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах” тусгай зөвшөөрлийг 5 жилийн хугацаагаар, 4-т заасан хуулийн этгээдийн “Радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах” тусгай зөвшөөрлийг 5 жилийн хугацаагаар, 5-т заасан хуулийн этгээдийн “Арилжааны телевизийн үйлчилгээ эрхлэх” тусгай зөвшөөрлийг 5 жилийн хугацаагаар тус тус сунгасугай.
2. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан тусгай зөвшөөрлийн хугацаа сунгагдсан хуулийн этгээдүүдтэй гэрээ байгуулж, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус Хорооны дарга /Г.Чинзориг/-д үүрэг болгосугай.

ДАРГА

ГИШҮҮД

Г.ЧИНЗОРИГ

Ч.ЗОЛБАЯР

Ө.ЗОЛБАЯР

А.ЛУВСАН-ОЧИР

Н.МАНДАХБААТАР

А.ҮЙЛСТӨГӨЛДӨР

Харилцаа холбооны зохицуулах хорооны
2023 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн
109 тоот тогтоолын
хавсралт

Тусгай зөвшөөрлийн хугацаа сунгасан хуулийн этгээдийн
жагсаалт

№	Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр	Тусгай зөвшөөр- лийн дугаар	Хугацаа	Хамрах хүрээ, Үйлчилгээний хүртээмж
1	Монгол инфинити шуудан ХХК	41200004	2023.08.31 2028.08.31	Харилцаа холбооны сүлжээ байгуулах, түүний ашиглалт үйлчилгээ эрхлэх /Шуудангийн сүлжээ байгуулах/
		43500011		Дотоодын шуудангийн үйлчилгээ эрхлэх
2	Очир роуд ХХК /Тусгал-1 телевиз/	13000083	2023.10.01 2028.10.01	Орхон аймгийн нутаг дэвсгэрт Өргөн нэвтрүүлгийн телевизийн үйлчилгээ эрхлэх
3	Түвдэнгийн бор интернешнл ХХК /Миний говь FM 104.1/	12800013 22800053	2023.09.12 2028.09.12	Өмнөговь аймгийн нутаг дэвсгэрт “Арилжааны радиоогийн үйлчилгээ эрхлэх” болон Өмнөговь аймгийн Даланзадгад сумын нутаг дэвсгэрт “Радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах”
4	Наран гүрт ХХК	23410047	2023.07.19 2028.07.19	Хөвсгөл аймгийн Мөрөн сумын нутаг дэвсгэрт “Радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах”
5	Парламентын суваг ХХК	12900003	2023.04.26 2028.04.26	Монгол Улсын нутаг дэвсгэрт “Арилжааны телевизийн үйлчилгээ эрхлэх”

----- оОо -----